



## АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ  
ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Агаарын орчны
- 3.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл
- 3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл
- 3.4. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл
- 3.5. Усны чанар, нөөцөд нөлөөлөх байдал

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ГОЛ ЗОРИЛТ

- 4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
  - 4.1.1. Агаарт чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
  - 4.1.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
  - 4.1.3. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
  - 4.1.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ
- 4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
- 4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 4.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
- 4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбрийн биелэлт
- 4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

ТАВ. ДҮГНЭЛТ



## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Талбайд 1986-1990 онд С.Гүрцоо, Д.Телеу нар 1:200000 масштабтай геологийн зураглалын ажлыг хийжээ. Энэ судалгааны дүнд геологийн карт зохиож, алт, ховор металл, зэс, молибден, вольфрамит, цагаан тугалга, төмөр, хайлуур жонш, өнгөт чулуу, барилгын материалын илэрц нээж нутаг дэвсгэрийн металлогений төрх төлөвт мезозойн магматизм онцгой үүрэгтэй болохыг тогтоосон байна. Түүнчлэн С.Гүрцоо, Д.Телеу нар дево +н, карбоны настай тунамал чулуулгийг давхраасуудад ялгаж ойролцоо газруудад алтны сарнилын хүрээ зурж бусад ашигт малтмалын зүй тогтлын талаар тойм мэдээлэл өгсөн. Орхоны талбайд А. Ганболд, Н. Энхцогт нар 1993-1996 онд 1:50000 масштабтай геологийн эрэл зураглалыг явуулж ашигт малтмалын талаар алтны орд байж болох дэвсгэр элементүүдийн зүй тогтлыг нарийвчлан судалсан байна. Энэ судалгааны явцад урьдчилан гаргасан мэдээллийг үндэслэн Монгол Газар ХХК-ийн геологичид 1998 оноос эхлэн хайгуулын ажлыг явуулж ирсэн байна.

“Монгол Газар” ХХК-ний геологийн алба нь 1998 оноос эхлэн геологи- хайгуулын нарийвчилсан судалгааг тус талбайд явуулснаар Хангайн нурууны синклиналийн бараг төвийн хэсэг болох энэ нутагт Өлийн голын алтны хүдрийн зангилааг шинээр нээн, түүний бүлэг ордуудыг (Ар чулуут 1 орд) судалж, алтны нөөцийг тогтоосон. Уг ажилд “Монгол Газар” компанийн геологичид болох Д.Баатар, Л.Батчулуун, Н.Баярсайхан, Н.Пүрэвдорж, минералогич Ж.Баярсайхан, өрмийн бригадын ахлагч төрийн соёрхолт Т.Баяраа, Б.Баянмөнх, Энхбаатар, Б.Батмөнх нар ажилласан.

Уулын ажлын төлөвлөгөөний төсөл хийгдэж буй “Ар чулуут 1” ордод “Монгол Газар” ХХК нь өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж нөөцийг химийн цэврээр /В+С/ 806.2 кг-р тооцон 2006 оны 3-р сарын 02-ны өдөр АМХЭГ-ийн Эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулсан байна. Энэ орд нь Улаанбаатар хотоос 500 км зайд орших ба бага зэргийн уул техникийн хүндрэлтэй боловч дундаж агуулга өндөртэй, жигд тархалттай, жилийн 4 улиралд авто тээврээр чөлөөтэй зорчих боломжтой тул манай “Алтай Голд” ХХК 2007 оноос энэхүү ордын тусгай зөвшөөрлийг шилжүүлж авсан.

Манай компанийн эзэмшлийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших MV\_12470 тоот тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 423 дугаар шийдвэрээр цуцалж, Захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр маргаан хянан шийдвэрлэгдэж 2021 оны 01 сарын 19-ний өдөр сэргээсэн билээ. БОННҮнэлгээний нэмэлт тодотголыг “Саблайм” ХХК боловсруулж БОАЖЯ-аар 2024 оны 06 сарын 27-ны өдөр баталгаажуулсан. 2024 оны 07 сарын 31-ны өдөр Усны газраас усны дүгнэлт гарч, 2024 оны 08 сарын 02-ний өдөр Орхон Чулуут голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулсаны дараагаар уурхайн үйл ажиллагаа эхэлсэн.


2024 онд Харгуйтын баруун салаа ордын доод давхаргын 9-В блокоос хөрс хуулалт, элс олборлолтын ажлыг эхлэх бөгөөд цааш доод давхаргын 9-В, 10-В, 11-В, 12-В, 13-В блокуудад уулын ажлыг хийнэ.



**Төслийн байршил.** Харгуйтын амны алтны шороон орд нь Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Улаанбаатар хотоос баруун зүгт 740 км, Өлийн голын хүдрийн дүүрэгт орших ба Хангайн уулархаг мужийн төвийн хэсэг, Орхон голын эх, ай сав газарт, байр зүйн зургийн L-47-48 хавтгайд байрлах бөгөөд засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт харъяалагдана.

Хүснэгт 1. Төслийн талбайн байршлын солбицол

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек		Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	101	46	18.64	101	46	18.64	14	101	45	44.28	101	45	44.28
2	101	46	18.64	101	46	18.64	15	101	45	41.3	101	45	41.3
3	101	46	17.39	101	46	17.39	16	101	45	30.63	101	45	30.63
4	101	46	14.03	101	46	14.03	17	101	45	30.63	101	45	30.63
5	101	46	10.96	101	46	10.96	18	101	45	20.69	101	45	20.69
6	101	46	7.12	101	46	7.12	19	101	45	5.59	101	45	5.59
7	101	46	2.61	101	46	2.61	20	101	44	54.64	101	44	54.64
8	101	45	55.06	101	45	55.06	21	101	44	54.64	101	44	54.64
9	101	45	54.19	101	45	54.19	22	101	45	18.63	101	45	18.63
10	101	45	54.14	101	45	54.14	23	101	45	18.63	101	45	18.63
11	101	45	54.14	101	45	54.14	24	101	45	52.63	101	45	52.63
12	101	45	48.99	101	45	48.99	25	101	45	52.63	101	45	52.63
13	101	45	48.95	101	45	48.95							



Зураг 1. Төслийн талбайн байршил

2017 оны 03 дугаар сард ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийн тусгай зөвшөөрөлтэй давхцалтай хэсгийг хасуулж нийт 176 га бүхий лицензийн талбай нь 141.4га талбай болсон.



Зураг 2. Харгуйтын баруун салаа алтны шороон ордын ерөнхий байдал



Зураг 3. Уурхайн кемпийн ерөнхий байдал



## ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Уур амьсгал.** Энэ бүс нутагт хүйтний улиралд баруун хойноос ирэх эсрэг циклон, дулааны улиралд баруун өмнөд талаас ирэх циклоны урсгалын нөлөөнд орших тул жилийн аль ч улиралд эдгээр урсгалууд холимог долгион үүсгэнэ. Энэхүү үзэгдэл нь Хангайн нурууны өндөрлөг газарт тунадасны хуримтал илүү их явагдаж, ууршдагаас хур тунадас элбэг байдаг. Жилийн тунадас хуримтлал 258 мм бөгөөд үүний 90% нь зуны улиралд орж голуудыг тэжээдэг болно. Өвөлд өндөр уулын бүсээр 10-20 см зузаан цас ордог. Агаарын дундаж чийглэг 58%, температурын хамгийн их нь зуны улиралд +25°, хамгийн бага нь өвлийн улиралд -31° хүрнэ.

**Уулзүй:** Ордын талбайн орчмоор хамгийн өндөр цэг нь далайн түвшнөөс дээш 2682.0 м өндөр Цагаануул, 2735.0 м өндөр Ар Улаан чулуут уул, хамгийн нам цэг нь Өлзийт голын савд 2010.3 м өргөгдсөн хөндий толгодорхог хэсэг болно. Нийт талбайн 80%-г 2200 м-с дээш өргөгдсөн уулс эзлэх ба ерөнхийдөө бөмбөгөр оройтой, эгц хажуутай. Шинэ төрмөлийн сүүлийн галавт болсон мөстлөг уулсын тогтцод гүн ул мөр үлдээсэн. Энэ үетэй холбоотой мөстлөгийн дэнжүүд болоод нарийн хавцлууд тохиолдоно. Уулсын оройгоор мөстлөгийн морен элбэг тааралдана. Мөн неогений базальтаар бүрхэгдсэн оройтой 2445.0 м өндөр Хөх хавцгай, 2245.0 м өндөр Хэцийн дөрөлж 2567.0 тоот өндөрлөгүүдийн дунд байрлана.

**Ус зүй:** Судалгааны талбай нь Хангайн нурууны томоохон голуудын нэгэн болох Орхон голын цутгал голуудтай Хангайн нурууны өврөөс эх авч талбайн баруун урдаас зүүн, зүүн хойш дайран өнгөрөх Орхон голд цутгах хүртэл Өлийн голд Өлзийттээл, Улаанчулуут, Гүүт, Билчир зэрэг байнгын урсгал устай олон ам жалга нийлдэг. Эдгээр нь тунгалаг устай, голын өргөн нь 1.5-10 м, гүн нь дунджаар 0.96 м ус нь гидрокарбонат найрлагатай байна.

**Ургамал амьтан:** Энэ нутагт ургамлын бүрхүүл, ан амьтан элбэгтэй. Талбайн нилээд хэсэг нь ойгоор бүрхэгдсэн ба энд хар мод, хус, хуш, шинэс, голчлон ургасан байдаг. Голын хөндийгөөр янз бүрийн бутлаг ургамал ургана. Амьтдаас буга, бор гөрөөс, нохой зээх, чоно, гахай, шилүүс, тарвага, мэргэчид, төрөл бүрийн шувууд бий. Голууд нь хайруус, зэвэг, цурхай зэрэг загастай.

**Суурин газар, зам харилцаа.** Ар чулуут 1 орд нь Цэнхэр сумтай 80 км шороон замаар холбогдсон. Тус сум нь шуудан холбоо, 12 жилийн сургууль, 14 ортой эмнэлэг болон үйлчилгээний төвтэй. Уурхайн талбайгаас лагер хүртэл 0.5 км зайтай. Ордын ойролцоо Өлзийт тээл, Баруун Сөдөтийн ордууд дээр “Алтан Дорнод Монгол” болон Гацуурт компаниуд үйл ажиллагаа явуулдаг. Тус бүс нутагт зун цагт шавар, намаг ихтэй байдгаас үүдэн автомашинаар зорчиход багагүй хүндрэл учирдаг байсан хэдийч “Монгол Газар” ХХК нь Өлийн давааны замыг засаж сайжруулсан байна. Архангай аймгийн төв Цэцэрлэг хот нь Улаанбаатар хотоос 490 км бөгөөд хатуу хучилттай замаар холбогдсон. Цэцэрлэг хотоос Цэнхэр сум хүртэл 20 км шороон замаар холбогдсон. Цэцэрлэг хот нь шилэн кабель, сургууль, цэцэрлэг, 60 ортой нэгдсэн эмнэлэг болон үйлчилгээний төвтэй.



**Ордын геологийн тогтоцын тухай мэдээлэл.** Харгуйтын амны баруун салааны шороон орд нь харьцангуй бага уналтай, тэвш маягийн тогтоцтой хөндийг дагаж тогтсон аллювиаль гаралтай голын сэвсгэр хурдсанд хуримтлагдсан учир ялгарал сайн явагдсан, тууз маягийн тогтоцтой юм. Энэ ордын алттай давхаргын алтны (дундаж агуулга) тархац харьцангуй жигд, тогтвортой, хучаас хурдас, давхаргын зузаан ордын хэмжээнд харьцангуй жигд үзүүлэлттэй юм. Судалгаа явуулсан талбай нь Хангайн нурууны атираат тогтолцооны төвийн хэсэгт багтах ба энд эхэн төрмөлийн хурдас зонхилон тархаж шинэ шинэ төрмөлийн хурдас харьцангуй бага талбайд тархжээ.

Давхарга зүйг насны дарааллаар авч үзвэл: Эхэн төрмөл дунд Девоны (D2) настай нэгэн төрлийн терриген хурдас, дунд Девоны настай (D2er) Эрдэнэцогтын давхаргадасын дундлаг найрлагатай бөсөл, бөсөл-элсжин, граувак элсжин, ягаан хүрэн улаан өнгийн хас, элсжин, хар өнгийн цахиурлаг зануужин, зануут элсжин, дунд-дээд Девоны (D2-3cc) ногоон саарал, цайвар саарал хааяа бараан саарал өнгөтэй конгломерат, гравелит, элсэн чулуу, алевролит ээлжилсэн флишлэг тогтоцтой тунамал чулуулаг болон дөрөвдөгчийн настай орчин үеийн тунамал хурдас тархсан байдаг.

**Гүний чулуулгийн бүрдэл.** Хожуу пермийн гүний чулуулаг нь цайвар, цайвар саарал өнгөтэй, том дунд ширхэгтэй боржин ба ногоовтор саарал, цайвар бараан өнгийн дунд ширхэгтэй боржин, диоритын фацаас бүрдэнэ. Боржингийн кварцын агуулга буурч өнгөт эрдсийн агуулга нэмэгдсэнээр боржин нь диоритод аажим шилждэг. Шилжилт нь 100-250 м үргэлжилнэ. Дотоод хил заагийн бүсэд девоны настай элсэн чулууны ксенолитууд тохиолдоно. Гүний чулуулаг нь лейкоборжин, лейко-порфиритын дэл судлуудаар хэрчигдсэн байдаг. Дэл судлууд ихэвчлэн босоо уналтай 0.5- 3.0 м өргөнтэй суналын дагуух урт нь 100-500 м хооронд хэлбэлзэнэ.

**Тектоник.** Судалгааны талбай нь Монгол-Өвөр байгалийн атираат системийн хэмжээнд байрлах бөгөөд тунамал, вулканоген-тунамал гүний формациас бүрдэх геологиструктурын нарийн тогтоц нь урт хугацааны түүхэн хөгжлийн явцдаа олон удаагийн атираажил, тектоник идэвхжилийн үйлчлэлээр өнөөгийн дүр төрхийг олжээ.

Хагарлуудын дотор уртраг, өргөрөг болон баруун хойш, зүүн хойш чиглэлийн бүлгийг ялгаж болох ба эдгээрээс эхний хоёр бүлэг нь давамгайлж байна. Дээрх хагарлуудыг дотор нь геологийн тогтоцоор ялгаатай томоохон нэгж болох цулдамуудыг үүсгэж байгаа голлох болон тэдгээрийн дотор янз бүрийн хэмжээтэй жижиг тектоник бүтцүүд-горст антиклиналь, грабен синклиналь, моноклиналийг үүсгэж байгаа хоёр гуравдугаар зэргийн нөлөөлөлтэй бусад хагарлууд гэж ангилж үзлээ. Голлох хагарлуудыг нэрлэвэл: Өлийн Орхоны Улиастайн Битүүтийн Гооронгийн зэрэг болно. Эдгээр нь гол төлөв эгц босоо, эсвэл бага зэргийн налуу уналтай хагарлууд бөгөөд ерөнхийдөө өөр өөр настай хурдас чулуулгаас бүрдсэн цулдамуудыг байгаа онцлог шинжтэй учраас эдгээрийн үүсэл хөгжил нь нилээд эртний бөгөөд олон удаа дахин сэргээгдэж байсан болох талтай. Дээрх хагарлууд дараах томоохон үндсэн 6 цулдам бүтцүүдийг зааглаж хязгаарладаг. Үүнд: Ар улаан чулуутын Байцын Хонгилын Хүрдэтийн Тооройтын Хужиртын орно. Эдгээр томоохон цулдамууд нь дотроо өргөргийн, баруун хойш, баруун болон зүүн хойш, чиглэлтэй бусад хагарлуудаар жижиг хэсгүүдэд хуваагддаг.

Геологийн бүтцээр дөрөвдөгч галавд хамаарах элс хайрга, шаварлаг, бал чулуу тогтоцтой.



Архангай аймгийн Өгий нуур сум Дөрөвдөгчийн ангилагдаагүй хурдас мөн орчин үеийн хурдас тархсан. Хашаат сумтай хиллэж буй хэсгээр -Дээд дөрөвдөгч орчин үеийн/голын/, дөрөвдөгчийн ангилагдаагүй хурдас, эльювийн десерцийн, делювийн дөрөвдөгч ангилагдаагүй хурдас, өмнө хэсгээр- Нуур голын дээд дөрөвдөгч, дээд дөрөвдөгч орчин үеийн хурдас, баруун хэсгээр- Эльювийн дөрөвдөгч ангилагдаагүй хурдас, зарим хэсэгтээ коллювийн хурдас бүхий дөрөвдөгчийн өмнөх үеийн чулуулаг, дээд дөрөвдөгчийн хурдас тархсан байна.

**Геологийн хэв шинж:** Цэнхэр сум нь рифейн өмнөх үеийн хувирмал чулуулгийн бүрдэл, бүтцүүд бүрэлдэн тогтсон үе шат. Энэ үед ул суурийн амфиболит гнейс, гантиг, кварцит зэрэг талст чулуулаг үүссэн хамгийн эртний (дээд архей-доод протерозойн). Геологийн бүтцээр дөрөвдөгч галавт хамаарах элс хайрга, шаварлаг, бал чулуу тогтоцтой.

**Цэвдэгийн тархалт:** Цэвдэгийн мужлалт алаг цоог ба ховор алаг цоог тархсан бөгөөд нутгийн баруун, хойд хэсгээр улирлын цэвдэг чулуулаг- Хөндий хотгорын жилийн дундаж температур 00 -+20 С улирлын хөлдөлтийн гүн 3,0-4,5 м 2,5-5,0 зүүн хэсгээр-жилийн дундаж температур +30 -+100 С улирлын хөлдөлтийн гүн 2,0-4,0, 2,0-4,5м байна.

**Газрын доорх усан орчин.** Гидрогеологийн шинж тэмдгээрээ газрын доорх усны тэжээгдлийн муж, хуримтлагдах талбай, усны урсгалын чиглэл, рельефийн хэрчигдлийн дагуух тектоникийн хагарал байж болох хил зааг чиглэл зэргээрээ сайн ялгагддаг гидрогеологийн энгийн нөхцөлд хамаарагдах Хангайн их мужийн төвийн зүүн өмнөд хэсэгт нэлээд өндөрлөг газарт оршино.

Талбайн хэмжээнд эртний мөстлөгийн процесс хүчтэй явагдсан шинж тэмдэг бүхий том том үхэр чулуунууд өргөн тархсан байхаас гадна намагжилт ихтэй, жижиг жижиг бөөрөгүүд, зарим газраараа томоохон овойлт үүсгэсэн дов байгаа нь цэвдэгт чулуулаг өргөн дэлгэр тархсаныг илчилнэ. Харгуйт-Шийртийн гол нь хоёр цутгал горхитой бөгөөд голын эх хавийн (хайгуулын шугам 16А, Улаан чулуутын шугам 21 орчимд) булгийн өрх хаанаас гарч байгаа нь мэдэгдэхгүй учир үүнийг "нисходящий" бүлэгт хамааруулав.

Харин Өлийн гол нь хуурай улиралд (хур тунадасгүй) үе үе тасардаг, байнгын цутгал голгүй. Хоёр голын нийт ундаргыг эзлэхүүний аргаар тодорхойлоход 10-12 л/сек болж байна. Голын ус нь өвлийн улиралд хөлддөг, зөвхөн агаарын хур тунадсаар тэжээгддэг, өнгө, үнэр амтгүй, цэнгэг устай. Энэхүү гол, горхид нь газрын доорх устай алив нэгэн гидравлик холбоогүй, дээр өгүүлснээр зөвхөн агаарын хур тунадсаар тэжээгддэг, урин дулааны улиралд байнгын урсгалтай байдаг нь жилийн тунадас хуримтлалаас нэлээд хамааралтай болох нь тодорхой байна. Харгуйтын амны баруун салаа, Хар чулуутын аманд байнгын урсгалтай гол, горхи байхгүй. Ордын газрын доорх усны судалгааг өмнөх хайгуулын ажлын явцад нэгэн зэрэг гүйцэтгэсэн юм. Тухайлбал, цооног өрөмдөх бүрд газрын доорх усны түвшин, тааралдсан цэвдгийн тухай мэдээллүүдийг өрмийн журналд тэмдэглэн, бичиглэл хийж байсан баримтуудыг тайланд ашиглав.



Харгуйтын ордын төв хэсэг гидрогеологийн нөхцөлийг судлах зорилгоор УКС-22 цохилтот өрмөөр Ш-58 -ийн 14 -р цооногийг 12.0 м-ийн гүнтэй өрөмдөж, 3.6-6.0 мт 8.5-12.0 м-т тус тус ан цавын усны үе илрүүлж, шавхалт туршилтын ажил явуулахад статистик түвшин нь 1.2 м, ундрага 2.2 л/сек, уст үеийн зузаан (2 үе) 5.9м, ус агуулагч нь ан цавчлагдсан, хагаралтай цахиурлаг элсэн чулуу бөгөөд цэвдэггүй гэж тогтоов.

**Гадаргын усан орчин.** Төслийн талбай ус зүйн сүлжээний хувьд Хойт мөсөн далайн ай савын Орхон голын сав газарт багтах бөгөөд Харгуйтын амны баруун салаа, Хар чулуутын аманд байнгын урсгалтай гол, горхи байхгүй байна. Орхон гол нь Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал бөгөөд Хангайн нурууны салбар уулс Суварга хайрхан уулын өвөр бэлээс эх авсан Их тээл гол, түүний цутгал гол болох Өлт голыг Орхон голын эх гэж үздэг.

Гол нь эхэн хэсэгтээ уулархаг, доошлох тусам дов толгод зонхилсон дунд зэргийн уулархаг гадаргаар, цаашлаад тал хээр, уулсын хөндийгөөр урсана. Хөндийдөө хүрмэн чулуун гүн хавцалтай, адагтаа гол өргөсөж олон салаа болдог. Орхон голын сав газар нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужид багтаж байгаа ба голын эхэн хэсэг нь Хангайн гол нурууны тойрогт, дунд ба адаг хэсэг нь Сэлэнгэ, Орхоны сав газрын дундаж өндөр уулсын тойрогт хамрагдаж байна.

Орхон голын сав газарт 8 аймгийн 53 сумын нутаг дэвсгэр ямар нэгэн хэмжээгээр багтаж байна. Архангай аймгийн Булган, Өлзийт, Төвшрүүлэх, Хотонт, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хужирт зэрэг сумдын нутаг бүтэн багтсан байна. Харин Архангай аймгийн Өндөр-Улаан, Чулуут, Эрдэнэмандал, Баянхонгор аймгийн Галуут, Булган аймгийн Гурванбулаг, Сэлэнгэ аймгийн газарт хамарч байна. Орхон голын сав газрын 38,2 хувийг Архангай, 22,1 хувийг Булган, 18,4 хувийг Баянхонгор, 1,6 хувийг Орхон, 0,4 хувийг Дархан-Уул аймгийн нутаг тус тус эзэлж байна.





## **ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

Уул уурхайн үйл ажиллагааны явцад алт олборлох технологийн бүхий л үе шатанд газрын хэвлийн эвдрэл, газрын доорхи усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар, ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөлөл зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

**Болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.** Хөрс хуулалт, металл олборлолт, овоолго байгуулах зэрэг үйл ажиллагааны явцад их хэмжээний шороо тоос босч агаар мандлыг бохирдуулж байдаг. Үүний зэрэгцээгээр уурхайд хэрэглэгдэж байгаа уулын болон технологийн тээврийн хэрэгслүүд бүгд дотоод шаталтын хөдөлгүүртэй учраас ажиллаж байхад ялгарах утаа, тортог агаар орчны хэсэгчилсэн бохирдолтыг бий болгож байдаг.

Үйлдвэрийн технологийн ажиллагааны явцад их хэмжээний тоос шороо босч салхиар зөөгдөн ойр хавийн ялангуяа салхины давамгайлах чиглэлийн дагуу хөрс ургамлын дарж байгалийн өнгө төрх алдагдуулж болзошгүй. Газрын гадарга, хөрс нь ахуйн хаягдал болон ашиглагдсан шатахуун тослох материалаар бохирдох магадлалтай.

Уурхайн олборлолтын ажил явуулахад газрын хэвлий, орчны эвдрэл тодорхой хэмжээгээр гардаг тул тоног төхөөрөмж байрлуулах, суурилуулах байгууламжуудын байршлыг зөв сонгох, үйлдвэр зохион байгуулалтын ажлыг зохих журмын дагуу хийснээр тухайн газар орчныг эвдрэлээс тодорхой хэмжээгээр хамгаалагддаг. Манай компани 2024 оны үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгахын тул дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.



### 3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Алтны шороон ордыг ашиглах үед хөрс хуулах, элс олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрийн үйл ажиллагаанд өртсөн ухаш, овоолгын талбай зэргээс салхинд хийсэх, тоосжилт үүсэх замаар агаарын чанарыг бууруулах сөрөг нөлөөлөл үзүүлэхээс гадна тэр нь салхины хурд, агаарын чийгшил, хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улирал харилцан адилгүй байдаг.

Уурхай дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь агаар бохирдуулагч цэгэн эх үүсвэрүүд болох ба автомашины хөдөлгүүрийн шаталтаас үүсэх дутуу хий агаар орчныг хорт хийгээр бохирдуулна. Түлшний эх үүсвэрээс агаарт гарах дэгдэлт нь уурхайн тоног төхөөрөмжийн ажиллагаанаас болон уурхайд ажиллах хүнд механизм болон тээврийн машинуудаас, бусад зөөврийн төхөөрөмжүүдийн ажиллагаанаас үүсэлтэй байна. Уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ ялгаруулалтын стандартууд болон түлш зарцуулалтын үр ашгийг нь харгалзан үзнэ.

Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед үүссэн тоос агаар орчныг бохирдуулахаас гадна хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Уурхайн эвдрэлд орсон талбайгаас үүсэх тоосжилтын хэмжээг тодорхойлвол:

$P=31500 \text{ м}^2 \cdot 1.0 \cdot 10^{-6} \text{ кг/м}^2 \cdot \text{сек} \cdot 0.1=0.031 \text{ кг/сек}$  буюу 111.6 кг/цаг, жилд(өдөрт 10 цаг жилд 184 хоног салхитай) үзэхэд 198.6 тн тоосжилт жилд үүсэхээр байна.

Хүснэгт 2. Тоосонцорын ялгаралт, кг

№	Тоосонцорын ялгаралт, кг				
	1 сек	1цаг	1 хоног	1 сар	1 жил
1	0.031	111.6	1116	33480	234360

### 3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Алт агуулсан элс угаах үйл ажиллагаа явуулахад ус их хэмжээгээр хэрэглэнэ. Мөн ажилчдын унд ахуйн зориулалтаар ус хэрэглэнэ. Усны газрын ус ашиглуулах дүгнэлтээр 2024 онд баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээ, унд ахуйн усан хангамж зэрэгт нийт 89,396.56 мян.м<sup>3</sup> ус хэрэглэхээр байна.

Хүснэгт 3. Уурхайн усны хэрэглээ

Усны хэрэглээний төрөл		Хэмжих нэгж	2024 он
Төлбөр тооцох усны хэрэглээ	Ашигт малтмал олборлох, баяжуулахад шүүрлийн усыг шавхан зайлуулахад газрын доорх ус	м <sup>3</sup>	82.300.06
	Нийт жилийн усны хэрэгцээ	м <sup>3</sup>	89.396.56
Төлбөр тооцохгүй	Унд ахуйн ус	м <sup>3</sup>	3024.0



Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын гадаргын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, тунгаан цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана.

Дахин ашиглагдаж буй усыг зөвхөн үйлдвэрлэлд ашиглах төдий биш мөн уурхайн талбай дахь тоосжилтыг дарах, талбайг чийгшүүлэхэд ашиглах, уурхайн шүүрлийн усыг тунгаан цэвэршүүлэн зам услах зэрэг ажилд ашиглана.

### **3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

Төслийн үйл ажиллагаанд нийт 3.5 га талбай бүхий намагт хөрс, хар хүрэн хөрс эвдрэлд өртөгдөнө. Уурхайн тосгон, баяжуулах үйлдвэр, уурхайн дотоод зам, барилга байгууламжийн улмаас хөрсний өнгөн хэсэг буюу ялзмагт давхарга устана. Ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдсоны улмаас газар доорх усыг бохирдуулах эрсдэлтэй.

### **3.4. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтонд ойролцоох талбайн ургамлан нөмрөг өртөж ургамлын ургах явц удааширч багтрах, ургамлын гадарга, навч өнгөө алдаж түлэгдэх сөрөг нөлөөтэй. Уурхайд ашиглагдаж буй машин техникээс гарс байгаа дуу чимээ болон шөнийн цагаар тусч байгаа хурц тод өнгийн гэрэлнүүдээс болж шөнийн амьдралтай амьтдын амьдрах нөхцөл хүндрэх ба хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад ихээхэн нөлөөлж байна.



## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

### **4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Ордод олборлолтын ажил явуулсанаар орд орчмын унаган төрх бага зэрэг алдагдахаас өөрөөр орон нутагт үзүүлэх сөрөг нөлөө бага боловч доорх арга хэмжээнүүдийг манай компани 2024 оны БОМТ-ний дагуу авч хэрэгжүүлсэн зарим нэг арга хэмжээнүүдийг дурдвал:

- Уулын ажлыг газар эдэлбэрийн хуулийн дагуу аймаг, сум, багийн засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн талбайд зөвхөн зураг төсөлд тусгагдсан хил хязгаарын дотор явуулсан.
- Хуулсан хөрсийг аль болох дотоод овоолгод хийхээр тооцож уулын ажлыг хийсэн.
- Угаах төхөөрөмжөөс гарч байгаа үйлдвэрийн хаягдал усыг эргүүлэн ашиглах, эргэлтийн усан санг байгуулж ажиллав.
- Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтэнд зориулагдсан замыг зөвхөн нэг маршрутаар хийсэн.
- Хуурайшилт тоосжилт ихтэй үед уурхайн технологийн процессын дагуу ухаж ачих, тээвэрлэх, овоолго хийх явцад тоосжилтыг багасгах замаар орчны агаарын чанарыг хамгаалж тээвэрлэлт хийх зам талбай болон овоолгыг усаар шүршин тоосжилтыг бууруулсан.
- Уурхайд ажиллах машин, техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засварыг хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд хийсэн.
- Ургамлын хар шороон хөрсийг тогтоогдсон хэмжээний зузаантайгаар олборлолт явагдах талбайгаас хуулан авч, тусгай овоолгод байрлуулсан.
- Хөрсийг гадаад овоолгоос ашиглагдсан хоосон орон зайд бульдозероор түрж, машинаар зөөвөрлөн авчирч тараан тэгшлэх, өнгөн хэсгийг хар шороон хэсгээр хучиж, биологийн нөхөн сэргээлт хийсэн.
- Орчны хяналт шинжилгээнүүдийг тогтоосон цэгүүдээс тогтмол хугацаанд авч шинжлүүлж гарсан үр дүнг харгалзан арга хэмжээнүүдийг авлаа.
- Хог хаягдлыг бууруулахын зорилгоор уурхайд аль болох нэг удаагийн хэрэглээг багасгав.



#### 4.1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Манай компани нь уулын ажлыг явуулахад тэсэлгээний ажил явуулдаггүй учраас агаарт дэгдэх хорт бодис нь зөвхөн техник тоног төхөөрөмжийн утааны ялгарал байдаг. Үүнийг стандарт хэмжээнд бариулахын тулд тоног төхөөрөмжийн техник үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэсэн. Уурхайн ухаш, замаас босох тоосыг усалгааны машинаар дарсан.

##### Хүснэгт 4. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал
1	Уурхайд ашиглагдаж байгаа техникийн агаар, тос маслын шүүрийг тогтмол хугацаанд сольж авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ авсан.	Ерөнхий механик	Машин механизмын засвар үйлчилгээг тогтмол хийж, тос, маслыг хугацаанд сольсон.	9,0
2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услаж байна.	Уурхайн дарга	Энэ жил хур бороо ихтэй байсан. Бороогүй, хуурай үед усалгааг хийв.	-
3	Агаарын чанарын хяналт шинжилгээ хийв.	БО-ны ажилтан	Агаарын шинжилгээг 1 цэгт 1 удаа хийгдлээ.	ОХШХ
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдсан машин механизмын агаарын төлбөрийг төлөв.	Нягтлан	Уулын ажилд хамрагдах 15 тээврийн хэрэгслийн агаарын төлбөрийг хийв.	1,33
Нийт				10,33



#### 4.1.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

- Уулын ажлыг зохих журам, стандартын дагуу явуулж, нөхөн сэргээлтийн ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэсэн.
- Уурхайн нүх болон овоолгуудыг үүсгэхдээ өөр зүйл ашиглаж болохуйц байдлаар хэлбэржүүлэн тохижуулах, мөн уурхайд хүн мал, амьтан унаж бэртэхээс хамгаалан тэмдэгжүүлэн ажилласан.
- Уурхайн олборлолт тээвэрлэлтийн ажлыг явуулахдаа газрын гадаргын хөрсөн бүрхэвчийг эвдэхгүй, олон зам гаргахгүй ганц замаар уулын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Шатах тослох материалын цехийг тусгайлан элс болон нарийн шлам асгац бэлдэж тэгшилсэн газарт барьж байгуулсан. Хэрэглэсэн тос, тослох материалыг цехэд хадгалдсан.
- Тос, тослох материал, масло асгаран хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас урьдчилан сэргийлж элс болон нарийн галь, шламыг зэрээг материалуудыг бэлдэж бэлэн байдалд ажиллаж байна.
- Галын аюулаас урьдчилан сэргийлж галын булангууд, галын хорыг байгуулж өгсөн.

#### Хүснэгт 5. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хийгдсэн ажил

Д.д	Хийгдсэн ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1.	Цэнхэр сумын ЗДТГ-тай Газар ашиглах гэрээ байгуулна	Компанийн захирал	Газрын төлбөр төлөх хүсэлтээ өгсөн. нэхэмжлэх үүсэхээр төлнө.	-
4.	ШТМ-ын алдагдлыг тогтмол хянаж, шинжилгээ тогтмол явуулж, бүртгэл хөтөлсөн.	Түлшний нярав, БО-ны ажилтан	ШТМ-ын асгалтыг тухай бүрд бүртгэл хөтөлөв. ШТС орчмын хөрсөнд 2 удаа шинжилгээ хийсэн.	ОХШХ-т тусгав
5.	Химийн бодисын хадгалалтыг, ашиглалтыг зөв явуулсан	Ерөнхий механик	Техникийн тос, будаг, лак, шингэлэгч, цавуу зэрэг химийн гаралтай бодисуудыг тусгай байгууламжид зохих хэмжээгээр хурааж, үйлчилгээ зарцуулалтыг гүйцэтгэх засварын цех байгуулан хяналт тавьж ажилласан	0,5
6	Хөрсний шинжилгээний төлбөр төлсөн	БО-ны ажилтан	Хөрсний агрохими, хүнд металлын шинжилгээнүүдийг 2 цэгт жилд 2 удаа шинжилгээ хийв.	ОХШХ-т тусгав
7	Засварын газар, сэлбэг хэрэгслийн 400м <sup>2</sup> талбайг бетондож, хатуу хучилттай болгосон.	Уурхайн дарга	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	0,5
<b>Нийт зардал</b>				<b>1,0</b>



Зураг 5. Шатах, тослох материалын агуулах болон ашигласан тос, масло хураах цэг



Зураг 6. Ашигласан тос маслыг хадгалах түр цэг

#### 4.1.3. Усан орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

- Шүүрлийн усыг хуримтлуулан технологийн усны хэрэглээнд ашиглах, зам усалгаанд ашиглах, Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашигласан.
- Бохир ус, элдэв хог хаягдлыг сайр, судгийн голдрилд хаяж, бохирдол бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.
- Ундны усны эх үүсвэрт тогтмол хими-бактерологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж, шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянаж ажиллав.
- Үйлдвэрлэлийн болон ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорхи усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажилласан.
- Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ мэргэжлийн байгууллагуудаар хийлгэв.
- Усны эх үүсвэрийн онцгой хамгаалалтын бүсийн цэгийг тэмдэгжүүлж, булгийн эхийг хамгаалав.



Хүснэгт 6. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний биелэлт

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1.	Орхон-Чулуут голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулсан.	Компанийн гүйцэтгэх захирал	2024.08.02-ний өдөр гэрээ байгуулсан. Усны төлбөр нийт 57 сая гарсанаас одоогоор 33 сая төгрөг төлөөд байна.	33,0
2.	Онцгой хамгаалалтын бүсийн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан ажлын тайланг “Мастерпойнт” ххк-аар хийж гүйцэтгүүлсэн.	Компанийн гүйцэтгэх захирал	Тайлан 2024.09.10. батлагдсан.	6,5
3.	Орчны Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу усны шинжилгээ хийлгэв.	БО-ны ажилтан	Усны шинжилгээг 3 цэг дээр 3 удаа хийлгэсэн.	ОХШХ-т тусгав
	<b>Нийт зардал</b>			<b>39.5</b>

#### 4.1.4. Ургамлын нөмрөг болон амьтны аймагт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоос босч салхиар зөөгдөн ургамлын нөмрөгийг бүрхэх, доройтолд оруулдаг. Үүнээс сэргийлж бид хуурайшилт ихтэй үед уурхайн гадаад болон дотоод замыг услах, аль болох олон салаа зам гаргахгүй байх, уурхайн гадаад тээврийн замыг сайжруулах, уурхайн тосгон, засварын цех, шатахуун түгээх станцын талбай, шатах тослох материалыг дахин боловсруулах цех зэргийн шимт хөрсийг тусад нь хуулж, тэдгээрийн доорхи эвдэрсэн газрын талбайг ихэсгэхгүй байх тал дээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Төслийн ажилчдад ан, амьтныг хамгаалах, хууль бус агналтыг гаргахгүй байх талаар сургалт явуулж, мэдээлэл сурталчилгаа хийсэн. Уурхайн тээврийн хэрэгслийн хурданд хязгаарлалт хийж, ажлын талбайн гадна шөнийн цагаар хурц, тод гэрэл ба дуу, шуугиан гаргахаас зайлсхийж ажиллав. Уурхайн эвдэрсэн газарт ашиглалтын үйл явцтай зэрэгцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, амьтдын унаган амьдрах орчныг бүрдүүлэх, сэргээхэд анхааран ажиллалаа.

Хүснэгт 7. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад авсан ажлууд

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1.	Олон салаа зам гаргахгүй ажиллав	Уурхайн дарга	Олборлолтын явцад шинээр зам гаргаагүй.	-
2.	Уулны ажил, орчны газар ашиглалтын үед тээвэрлэлтээс тоосжилтоос үүсч, ургамлын ургах орчин доройтно. Тоосжилтыг бууруулах, шаардлагатай үед дотоод тээврийн замыг услах арга хэмжээ авна.		Тоосжилтыг бууруулах зорилгоор зам усалгааны ажил тогтмол хийгдсэн	Дотоод зардлаар





3. .	Уурхайд ашиглаж байгаа гал унтраах багаж хэрэгслийг шалгаж агуулахаас шинээр 15 ширхэг галын хорыг зохих газарт нь байрлуулав.	Уурхайн дарга ХАБЭА	Галын аюулгүй байдлыг ханган ажиллав	1.0
	<b>Нийт</b>			<b>1.0</b>



Зураг 8. Гал хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал

#### 4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт


**А. Техникийн нөхөн сэргээлт.** Манай компанийн эзэмшлийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших MV\_12470 тоот тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 423 дугаар шийдвэрээр цуцалж, Захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр маргаан хянан шийдвэрлэгдэж 2021 оны 01 сарын 19-ний өдөр сэргээсэн билээ. БОННУ нэлгээний нэмэлт тодотголыг “Саблайм” ХХК боловсруулж БОАЖЯ-аар 2024 оны 06 сарын 27-ны өдөр баталгаажуулсан. 2024 оны 07 сарын 31-ны өдөр Усны газраас усны дүгнэлт гарч, 2024 оны 08 сарын 02-ний өдөр Орхон Чулуут голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулсаны дараагаар 8 сараас уурхайн олборлолт эхэлсэн.



Төлөвлөгөөнд 5 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр тусгасан байсан. Уулын ажлын төлөвлөгөөгөөр уурхайн үйл ажиллагаа 4 сараас эхлэн 11 сар хүртэл явагдаж, 8В, 9В блокуудыг олборлоно гэж тусгасан боловч 4,5,6,7 саруудад олборлолт явагдаагүй. Уурхайн бичиг баримт оройтож бүрдсэнээр уурхайн олборлолт 8 сараас эхэлсэн бөгөөд 8В блокийн 70 хувийг ч олборлож дуусаагүй явж байна. Нээсэн блокийн олборлолтын үйл ажиллагаа дуусаагүй, өөр нөхөн сэргээх талбай байхгүй учир хуучин байсан цэвэршүүлэхийн нууран дээр 1,8 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 9. Техникийн нөхөн сэргээлт хийж буй үйл явц



Зураг 10 . Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайн ерөнхий байдал 2024.11.08.

**Б. Биологийн нөхөн сэргээлт.** БОННУ-гийн тайланд тусгаснаар төслийн 2 дах жилээс биологийн нөхөн сэргээлтийг эхэлнэ.



#### 4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлүүлэлт	Зардал /сая.төг/
1.	Дүйцүүлэн хамгаалах ажиллагааны ургамлын нарийвчилсан судалгааг хийх	Компаний захирал	Энэ жилийн хувьд уурхайн үйл ажиллагаа 8 сараас оройтож эхэлсэн тул судалгааны ажил хийж амжаагүй. Төсөл хэрэгжих хугацаанд ургамал амьтны нарийвчлан судалгааг хийлгэхээр тусгасан байгаа тул 2025 оноос судалгааны ажлыг мэргэжлийн хүмүүсээр жил болгон хийлгэн ажиллах болно оо.	-
	Ховрын статустай ургамлыг дүйцүүлэн хамгаалах газарт шилжүүлэн суулгах, тарималжуулах			
	Амьтны аймгийн судалгааг нарийвчлан хийх			
	Мониторингийн хяналтын цэгийг тогтоож тогтмол хяналт тавих			
2.	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	БО-ажилтан	Булгийн эх хашаалах ажлыг “Бодьгал орхон” нөхөрлөл нь 2024.10.30-ний өдрийн ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийж гүйцэтгэнэ.	14.0
	Орхон-Чулуутын сав газрын захиргаанаас санал болгосны дагуу Нэг сум нэг хөв арга хэмжээний хүрээнд Архангай аймгийн Төвшрүүлэх сумын нутагт байрлах баахан булгийн эхийг хашаалж, хамгаалсан. Хөв цөөрмийг сэргээх ажлыг хавар газар хэссэн үед үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.			
3.	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах			-
4.	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын төвийн нийтийн эзэмшлийн хашаанд 500 ширхэг мод тарихаар төлөвлөсөн байсан ч модоо буруу сонгосон учир дараа жил нөхөн тариалахаар болсон.	Гүйцэтгэх захирал	Тариалах модыг зөв сонгох	-
<b>Нийт зардал</b>				<b>14,0</b>



Зураг 11. Төвшрүүлэх сумын нутаг дах Баахан булгийн эхийн талбайн зураг



Зураг 12. Төвшрүүлэх сумын нутаг дах хөвийн талбайн зураг



Зураг 13. Булгийн эхийг хашаалж буй үйл явц



Зураг 14. Булгийн эхийг хашаалсан байдал

#### 4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2024 оны уурхайн олборлолтын явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөөлсөн болон байгалийн гамшигт үзэгдлээс болж өртөгдсөн иргэдийг нүүлгэн шилжүүлэх ямар нэгэн асуудал гараагүй болно.

#### 4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө



“Алтайголд” ХХК-ийн “Харгуйтын баруун салаа”-ны алтны шороон ордын хайгуулын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтанд ямар нэгэн дурсгалт зүйл илрээгүй.

#### 4.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

#### 4.7. Хог хаягдлын менежментээр сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

Тус компани нь түүхий нүүрс хэрэглэхээс бүрэн татгалзаж, сумаас түлээний мод бэлтгэх зөвшөөрөл авч, уурхайн хотхоны байрнуудыг модоор галлав. Уурхайн ажилчдад нэг удаагийн хэрэгслэлийг аль болох багасгах, байгальдаа хог хаяхгүй байхыг уриалж, сургалт сурталчилгаа хийсэн. Жолооч нар машиндаа байнгын хогийн ууттай явж заншив. Уурхайн машин механикмын засвар үйлчилгээнд тос арчих зориулалтаар хуучин хувцас авч ашиглаж, бүх ажилтан албан тушаалтнууд нь ахуйн хог хаягдлаа дахин ашиглагдах боломжтой хогнуудыг ялган хаядаг болсон. Архангай аймгийн байгаль орчны газар хүсэлт гарган аюултай хог хаягдал үүсгэгийн код Y002003 авсан.

Ахуйн бохироо үнэргүйжүүлэх, ариутган халдваргүйжүүлэх зорилгоор ШУА-ийн ХХТХ-ийн дэргэдэх “Хийрэв” ХХК-ийн “Ариусан” бэлдмэлийг тогтмол хугацаанд хийж үнэргүйжүүлэв. Мөн Халдваргүйжүүлэлт ХХК-ийн халдгүйжүүлэх химийн бодис болох Гипохориткальцийг зааврын дагуу уусмал бэлтгэн усны нөөцийн сав, гал тогоо, халуун усны газар болон нүхэн жорлонгийн орчим, шингэн хаягдлын сан орчмыг ариутгаж, халдваргүйжүүлэв.

**Ахуйн энгийн хог хаягдал.** Ахуйн хэрэглээнээс гарсан энгийн хатуу хог хаягдалд хоол хүнсний хаягдал болон бусад төрлийн хаягдлыг авч үзлээ. Уурхайн байршил нь сум орон нутгаас алслагдмал тул хөрсний бохирдлыг аль болох бага байлгах үүднээс ахуйн хогийн цэгийг байгуулсан.



Зураг 15. Ахуйн болон төмрийн хог хаягдлын цэг



Хүснэгт 8. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлсэн ажлууд

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1.	Цэнхэр сумын ЗДТГ-тай 2024.04.30-ний хог хаягдлын гэрээ байгуулсан	Гүйцэтгэх захирал	Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлсөн.	2,5
2.	Ахуйн хатуу хог хаягдлаа ангилан ялгаж хэвшив. Энгийн хог хаягдлыг хадгалах хогийн бункер шинээр байршуулсан	Кемп менежер БО-ны ажилтан	Энгийн хог хаягдал хийх хогийн савыг нэмж байрлуулав.	0,5
3.	Ахуйн шингэн хог хаягдлаас үүдэлтэй бохирдлыг хянах зорилгоор шинжилгээ хийлгэв	БО-ны ажилтан,	Тогтоосон 5 цэгээс хөрс, усанд шинжилгээ хийлгүүлсэн. авсан.	ОХШХ-д тусгав
4.	Ундны усны нөөцийн сав болон ахуйн шингэн бохирдлын орчмыг мэргэжлийн байгууллагаас өгсөн зааврын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлууд хийв.	Кемп менежер, БО-ны ажилтан	Шинжилгээний үр дүнг үндэслэн бохирдсон газрыг халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөгөөний дагуу явуулсан. Ариун сан бэлтгэл 15 ш, гипохлориткальцийн давсыг зааврын дагуу уусмал бэлтгэн нүхэн жорлон, гал тогоо болон шингэн хаягдлын санг ариутгав.	0.5
5.	Овор ихтэй томоохон сэлбэг хэрэгслэл болон бусад тоног төхөөрөмжийг төмрийн хаягдалд оруулав.		Төмрийн хаягдлыг аль болох бага газарт эмх цэгцтэй байрлуулан, хөрс бохирдохоос сэргийлж байнгын хяналт хийв.	-
6.	Стандартын шаардлага хангасан эко жорлон суурилуулна	Гүйцэтгэх захирал БО-ны ажилтан	Энэ жилийн хувьд Стандартын шаардлага хангасан эко жорлон суурилуулах ажлууд төлөвлөгдөж байгаа ч хугацаандаа амжихааргүй байгаа тул ирэх жил энэ ажлаа үргэлжлүүлэх хийх болно.	-
<b>Нийт зардал</b>				<b>3,5</b>

Хүснэгт 8. Уурхайгаас сард ялгарах ахуйн бохирын тооцоо

Өгөгдөл	Хэмжээ	Шалгуур
Хугацаа	30 хоног	Нэг сараар тооцсон
Хүний тоо	65	Уурхайн ТЭЗҮ авсан.
Хүний нэг өдөрт ялгаруулах өтгөний хэмжээ	0.2л	Дэлхийн эрүүл мэндийн газрын гаргасан тооцоо
Хүний нэг өдөрт гаргах шингэн хаягдлын хэмжээ	1.5л	
Тооцоо: $30 \times 65 \times 0,2 = 390\text{кг}$ $30 \times 65 \times 1,5\text{л} = 2925\text{л}$ $390 + 2925 = 3315 = 3,3\text{м}^3$		





